



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/21

Өвт

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Зорилтот жил болгон зарлах тухай” 2019 оны 12/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2019 оны А/764 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Өвөрхангайд үйлдвэрлэв” жилийн ажлыг сумын хэмжээнд удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Бат-Эрдэнэ-Засаг даргын Тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга: Н.Түвшин-Хөдөө аж ахуйн тасгийн жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Д.Бадамдулам-Санхүү албаны дарга
Б.Янжиндулам-Байгаль орчны хяналтын улсын байцаагч
Н.Долгормаа-Халамжийн нийгмийн ажилтан
Х.Нямлхагва-Бизнесийн тэргүүн
Х.Алтанцэцэг-“Хамтын хүч хоршооны” тэргүүн
П.Аюушжав-Мал эмнэлгийн улсын байцаагч
Т.Жамъянжав-1 дүгээр багийн Засаг дарга
Д.Даваацэрэн-2 дугаар багийн Засаг дарга
С.Төмөр-3 дугаар багийн Засаг дарга
Г.Пүрэвтогтох-4 дүгээр багийн Засаг дарга
Л.Балжинням-5 дугаар багийн Засаг дарга

2. “Өвөрхангайд үйлдвэрлэв” жилийн хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцон ажиллахыг ажлын хэсэг (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

М.ЖАМЪЯНШАРАВ



D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

051011041